

**“МОНИНЖБАР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Улаанбаатар хот

№01

2014 оны 3-р сарын 28

Хурал “Монинжбар” ХК – ийн хурлын танхимд 16:20 цагт эхлэж, 19:45 дуусав.

Хурлаар хэлэлцэх асуудлууд

- 1.2013 оны компанийн үйл ажиллагааны тайлан
- 2.2013 оны санхүүгийн тайлан
- 3.Ногдол ашгийн тухай
- 4.2014 оны төлөвлөгөө

Хурлын дэг

- | | |
|--|-------------|
| 1.Тооллогын комиссыг сонгож батлах | 16.00-16.20 |
| 2.Хурлын ирцийг бүртгэх | 5 минут |
| 3.Хурлын ирцийг мэдээлэх | 10 минут |
| 4.Хурлын даргыг сонгох | 5 минут |
| 5.Хурлын дарга хурлыг нээж үг хэлэх | 5 минут |
| 6.Гүйцэтгэх Удирдлагын 2013 оны ажлын тайлан | 10 минут |
| 7.Компанийн 2013 оны санхүүгийн үйл ажиллагааны тайлан | 10 минут |
| 8.Хувь нийлүүлэгчидээс үг хэлэх, санал гаргах /1 хүнд/ | 5 минут |
| 9.Хурлаас гарсан тогтоолын төслийг танилцуулах | 10 минут |
| 10.Хурлыг хаах | 10 минут |

Гүйцэтгэх захирал Б.Баярсайхан хурлын дэгийг танилцуулж, хурал эхлэхээс өмнө хурлыг удирдаж явууллаа.

Б.Баярсайхан: Хурлын дэгийн дагуу тооллогын комиссыг тогтооё. Миний хувьд хурлын нарийн бичиг Н.Энхчулууныг сонгох саналтай байна. Та бүхэн саналаа хэлнэ үү. Гишүүдэд татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй 100 хувь зөвшөөрсөн тул ХНХ – ын тооллогын комиссоор Н.Энхчулууныг сонголоо.

Н.Энхчулуун: /Саналын эрхтэй хувьцааг тоолов/ Хувь нийлүүлэгчдийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцааг тоолоход

- Итгэмжлэлээр оролцож байгаа 7 хүн – 6 526 078 ширхэг,
- Би Ди Сек БДК – д итгэмжлэсэн 3 хүн – 5 152 850 ширхэг,
- Би Ди Сек БДК – ийг төлөөлөн оролцож буй 1 хүн – 6 150 ширхэг,
- Биеээр ирж оролцож буй 3 хүн - 357 592 ширхэг,
- Урьдчилан санал өгсөн 113 802 ширхэг,
- 2014 оны 2 – р сарын 07 – ны өдрөөр ҮЦТТТХТ - өөс гаргасан тус

компанийн хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаагаар нэр нь гараагүй 1 хүн байна. Тус компанид 297 иргэн 15 869 233 ширхэг хувьцааг эзэмшдэгээс хуралд оролцож буй 5 хүний 12 156 472 ширхэг саналын эрхтэй хувьцаа цугларсан байна. Үүнийг хувиар авч үзвэл 76.6 хувийн ирцтэй байна. Энэ нь Компанийн дүрмийн 7.4 – т

“Хувьцаа эзэмшигчдийн хурал нь саналын эрхтэй нийт хувьцааны 70-иас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч буюу тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцсоноор хүчин төгөлдөр болно. Санал авах хуудсаар саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хуралд оролцсонд тооцно” гэж заасныг хангаж байгаа тул хурлыг хүчин төгөлдөр гэж үзэж хурлыг эхлүүлэхийг зөвшөөрч байна.

Б.Баярсайхан: Та бүхэнд тооллогын комиссоос гаргасан ирцийн мэдээлэлд өгөх санал, хүсэлт байна уу. ... „Байхгүй“ бол тооллогын комиссын тогтоолыг гаргая.

Н.Энхчулуун: “Хувь нийлүүлэгчдийн хурлын 2014 оны 3 – р сарын 28 – ны өдрийн 01 тоот тогтоол”-ыг гаргаж танилцууллаа. /Тогтоолыг уншиж танилцуулав/

Б.Баярсайхан: Хурлын дэгд зааснаар ХНХ – ын даргыг сонгоё. Өмнөх жилүүдэд ХНХ – ын даргыг компани удирдаж буй хүнийг нь сонгоод явчихдаг байсан. Та бүхэн ямар саналтай байна вэ?...

Татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй тул Хурлын даргаар компанийн Гүйцэтгэх удирдлага Б.Баярсайханыг сонголоо.

Б.Баярсайхан:

Юуны өмнө эрхэм хувьцаа эзэмшигчид болон хөндлөнгөөс хяналт тавин оролцож байгаа та бүхэнд хуралдаа хүрэлцэн ирсэнд талархал илэрхийлье. Ингээд та бүхэндээ компанийн 2013 оны үйл ажиллагааны тайланг танилцуулъя.

Та бүхэнд хурлын материалууд очсон байгаа. Манай компани нь 2013 онд нэлээн үр дүнтэй ажилласан. 7.5 тэрбум төгрөгний барилга угсралтын ажлын гэрээ хийснээс 5.8 орчим төгрөгний барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн. 1.8 орчим төгрөгний дутуу байгаа нь он дамжиж байгаа ажлуудын хөрөнгө юм. 2014 он барилга угсралтын ажил үргэлжлээд ирэхээр санхүүжигдээд явна гэсэн үг юм.

2013 онд манай байгууллага 5 ажилд гүйцэтгэгчээр оролцлоо. Үүнд:

- 1.Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны төслийн хүрээнд Барилга-Дэд бүтэц төслийн хүрээнд Хан-Уул дүүргийн Буянт-Ухаа орон сууцны хорооллын цэвэр усны эх үүсвэрээс насос станц хүртэлх ф400 мм-ийн 2863 м хос шугам, насос станцаас кольцо шугам хүртэлх 546 м, нийт 3884 м шугам хоолой, 120 м нэвтрэх сувгийн барилга угсралтын ажил /цх7-цх23 хүртэл 1087 м, цх28-цх1 хүртэл 546 м шугамын ажил, 140 м нэвтрэх сувгийн барилга угсралтын ажлыг “Санжат” ХХК – тай түншлэлийн гэрээгээр гүйцэтгэсэн. Энэ ажил нь он дамжиж байгаа бөгөөд энэ онд 480 орчим сая төгрөг дутуу байгаа.
- 2.Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын захиалгаар 3.385 тэрбум төгрөгийн өртөгтэй Багануур дүүргийн цэвэр усны 2 – р ээлжийн шинэчлэлтийн ажлыг 2014 оны 7 – р сарын 4 - өөс 2014 оны 12 – р сарын 10 – ны дотор хийж гүйцэтгэлээ. Багануур дүүргийн цэвэр усны эх үүсвэрээс усан сан хүртэлх нийт 7.5 км, яг шугамын угсралтын ажил нь 15 км ажил байсан. Энэ ажлыг бид богино хугацаанд чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэсэн. Мөн дээрх ажилд манай байгууллага ханшийн зөрүүнээс 113.1 сая төгрөгийн алдагдал хүлээсэн ч энэ ажил маань байгууллагын нэр хүндэд маш өсгөж өгсөн үр дүнтэй ажил байсан. Дээрх ажилд 1 бригад ажилласан. Тендерээ аваад байдаг бол 1 бригад жилд 3-4 тэрбум төгрөгний ажлыг БУА – ын улиралд гүйцэтгэх боломжтой юм байна гэсэн дүгнэлтэд хүрсэн. Манай 4-5 бригад ажиллах зохион байгуулалт хийж чадахаар байгаа. Гэвч тендер маань бидний хүчин чадлыг 100 хувь ашигласан тендерийг авч чадахгүй байна. Үүнд улс төр, бонус зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байна.

3. Дэд бүтэц-Эрчим хүч төслийн хүрээнд нь Баянголын аманд "Гандирс" хорооллоос "Бортолгой" хүртэл дулааны гол шугамын Өргөх насос станцын зураг төсөл, барилга угсралтын ажлыг бие даан гүйцэтгэж байна. 3.450 төгрөгний төсөвт өртөгтэй. Он дамжиж хэрэгжиж байгаа. 1.3 тэрбум төгрөгний санхүүжилт авсан. Ажлын явц 70 орчим хувьтай байна. Бид 2014 оны 4 сарын 01-нээс ажилдаа гараад энэ оныхоо 6-р сарын 01 нд хүлээлгэн өгөх төлөвлөгөөтэй ажиллаж байна.
4. Баянзүрх дүүргийн Ногоон зоорь. Энэ ажил 2012 онд эхлээд 2013, 2014 онд хэрэгжиж байгаа. Нийслэлийн хөрөнгө оруулалтаас захиалгатай ажил. Энэ ажлын явцад зураг дутуу. Хөрөнгө нь дутуу тавигдсан. Техникийн нөхцөл гараагүй гэсэн шалтгаантай дуусахгүй байна. Энэ нь бидний талаас шалтгаалсан зүйл бол биш юм. Хөрөнгө нь дутуу тавигдсан. Энэ онд гүйцээж тавихаар НИТХ –аар батлагдаж байна. Дахиад 1 тэрбум гаран төгрөгийн шаардлагатай байгаа.
5. Ховд аймагт баригдаж байгаа ажил. Энэ тухай сүүлийн 2 жил тайланд орж байгаа. Дутуу хөрөнгө тавигдсан, дутуу зураг төсөлтэй зарлагдсан. Оны эцэст төсвийн хөрөнгө хураалгахгүйн тулд дутуу зарласан тендер байсан. Бид тэрэнд оролцоод авчихсан. Гүйцэтгэх болохоор 1 – рт Ховд аймагт баригдах цэвэрлэх байгууламжийн газар нь шийдэгдэхгүй, 2-рт үлдэгдэл хөрөнгө байхгүй. Одоо хийгдэх, хийгдэхгүй нь шийдэгдэхгүй бид 180 гаруй сая төгрөгийн материал авчиргаад хадгалаад 3 жил болж байна.
- Үндсэндээ өнгөрсөн энэ жил 3 ажил хийгдэх нөхцөл нь бүрдэхгүй байгаад байна.
6. Дамбадаржаагийн гэр хорооллын ажлыг 2010-2011 онд хийсэн. 2013 онд нэмэлт хөрөнгө тавигдаад ажилласан. Комисс ажилласан боловч Цэвэрлэх байгууламжийн зургийн алдаанаас болоод бүрэн ажиллаж чадахгүй байж байгаа. Манай байгууллагын хувьд шугамын ажлыг нь хийсэн. 2 компани орсон болохоор цэвэрлэх байгууламжийн техникийн буруу шийдэл, алдаанаас болоод Улсын комисс хүлээн авахгүй хүлээгдээд байгаа.
7. Дарь Эхийн гэр ажил 2004, 2005, 2006 онд хийгдсэн ажил. 2013 онд 2 – р ээлжийн ажил гэж 112 сая төгрөг тавьж өгсөн. Ажлын явц 80 гаруй хувьтай байгаа. Цахилгааны шийдэл гараагүй, халаалтын кабелийн тэжээлийн цахилгааныг шийдэж чадахгүй байна гээд бас он дамжуулчихсан байгаа. Эндээс гүйцэтгэгч байгууллагуудыг улсын болон зураг төсөл зохиож байгаа байгууллагууд маш их хохироодог юм байна гэж харагдаж байгаа юм. Гүйцэтгэгч байгууллагыг л ажлаа хугацаанд хийхгүй гээд байдаг боловч цаана нь зураг төсөл нь бүрэн зурагдаагүй дутуу, техникийн нөхцөл нь шийдэгдээгүй зэрэг биднээс шалтгаалахгүй олон хүчин зүйлүүд байдгаас 3 ажил он дамжиж дутуу хийгдсэн. Гэхдээ энэ байдалд аль аль компани нь хариуцлага хүлээхгүй гэдгийг та бүхэнд баттай хэлж байна.
- Мөн өнгөрсөн жил хэдийгээр 5.7 тэрбум төгрөгний ажил хийгээд 600-700 сая төгрөгийн ашиг хүлээж байсан. Энэ жилийн хувьд 251 сая төгрөгний ашигтай ажиллалаа. Валютын ханшийн өсөлт их нөлөөлөө. Бид нодлин 2 тэрбум гаран төгрөгний гадаад захиалга хийсэн. Гэрээ байгуулах үеийн болон худалдан авах үеийн ханш гэж гаргасан. Энэ дээр 500 гаруй сая төгрөгийн алдагдал хүлээсэн. Энэ алдагдлын талаар бид банк санхүүгийн байгууллага болон МҮХАҮТ яриж байна. Хамгийн сүүлд 2014 оны 3 сарын 8 нд болсон МҮХАҮТ – ийн хурал дээр ханшийн зөрүүний энэ алдагдалд төр хариуцлага үүрэх ёстой. Бид нарын гэрээнд болохоор ямар нэгэн үнийн зохицуулалт байхгүй хийгддэг. Бид ажилтай байхын тулд улсын аманд ороод гэрээний төслийнх дагуу л ажил хийх гэрээгээ зурдаг. Манай байгууллагатай ижил үйл ажиллагаа явуулдаг 3-4 компани яг л энэ шалтгаанаар тендерт оролцох боломжгүй болж байна. Ноднингийн хувьд 130

орчим ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явууллаа. Ажлын нөхцөлөөс шалтгаалаад туслах ажилтан авдаг. Байнга 100 гаруй хүнийг бүрэн цалинжуулаад ажиллах нь бидэнд маш хүнд байдаг. Ийм учраас ИТА – д маань туслах ажилчид авдаг. Энэ хүмүүсийн цалин өдрийн 30-40 төгрөгний цалин авахаар үндсэн ажилчдаас илүү цалин авдаг. Ийм учраас өнгөрсөн жил ажилчдынхаа цалинг 30 орчим хувиар нэмэгдүүлсэн. Мөн ажилчдаа барьж тогтоохын тулд шагнал урамшуулал, инженер техникийн ажилчдаа идэвхжүүлэх зэрэг үйл ажиллагаанд 20 орчим сая төгрөгийг зарцуулсан байгаа. Бригадуудын хороонд уралдаан зарлаад сар бүр дүгнээд урамшуулж ирлээ.

С.Мягмарсүрэн:

Одоо яг үндсэн хэдэн ажилчидтай, хэдэн бригадтай байна вэ?

Б.Баярсайхан:

Үндсэн 7 инженертэй, 23 мэргэжлийн ажилчидтай. Нийт 50 гаруй ажилчидтай. Тэтгэвэрт гарсан инженерүүд маань ажиллаж байгаа.

С.Мягмарсүрэн: Үйлдвэрлэлийн талаар ямар үйл ажиллагаа явуулж байна вэ? Тайланд бетон хийцийн үйлдвэрлэл гэсэн байна.

Б.Баярсайхан:

Бетон хийцийн үйлдвэрлэл байгаа ч тоног төхөөрөмж нь нэлээн хуучных. Зуны цагт хотод байгаа ажлуудын хэрэгцээг хангах зориулалтаар л ашиглагдаж байна. /Ялуу, кольцо г.м/. Зөвхөн тендерийн хамааралтай байхаар өсөж дэвжихгүй байна. Иймд байнгын хөрөнгө эргэлддэг үйлдвэрлэл эрхлэхгүй бол болохгүй байна.

С.Мягмарсүрэн: ХММ – ын худалдаа засвар, үйлчилгээний үйл ажиллагаа чинь явж байгаа юу?

Б.Баярсайхан: Бид Солонгосын DEAWOO – ийн гэрээт борлуулагч хийдэг байсан боловч нодлин өөр байгууллагыг сонгосон. Тэгэхдээ өөрт байгаа ХММ-уудаа түрээсэнд өгөөд тодорхой хэмжээний орлого олж байгаа.

С.Мягмарсүрэн: Ажлын байрны түрээсийн хувьд...

Б.Баярсайхан: Түрээс гэхээр 1 сургууль л байгаа. Тодорхой хэмжээний түрээс төлдөг ч өөрсдийн ажилчдын хүүхэд сурдаг тул түрээс гээд шахаад байдаггүй. Төлдөг 5 байгууллага л байгаа.

С.Мягмарсүрэн

Энэ байшин тэр чигээрээ танай байгууллагын эзэмшил үү?

Б.Баярсайхан:

Манай байгууллага нийт талбай нь 828м². Караоке манайд хамаарахгүй. Хувьчлагдахдаа энэ хэсэг л манайд үлдсэн байдаг. Бид энэ газраа эргэлтэд оруулъя гээд “Сан” ХХК, “УБ барилга” ХХК хамтраад газраа нийлүүлээд барилга барья гээд ярилцаад төсөл гаргачихаад явж байгаа. Манай өөрийн газрын хэмжээ 3400 орчим м² 0.9 га болж байгаа.

2014 онд нэлээд хэдэн тендерт оролцлоо. Одоогийн байдлаар 20 гаруй тэрбум төгрөгний тендерт оролцсоноос 2 тендерт ялаад байна. 1 ажил нь Азийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалттай. Одоо 3 тендерт орохоор бэлтгэж байна.

Нэг баяртай мэдээ дуулгахад 2011 оноос эхлээд 6 компани Зам-Үүд – Алтанбулаг чиглэлийн 1000км хурдны замын ажлыг гүйцэтгэх төсөл боловсруулаад 3 дах жилдээ явж байна. Нийт өртөг нь 5 тэрбум долларын өртөгтэй. 2014 оны 3 сарын 16 нд ЗГ – тай концесийн гэрээ байгуулсан. Нийт өртөгийн 50 хувь нь буюу 2.5 тэрбум шийдэгдсэн. Үлдэгдлийг нь санхүүжүүлъя гэсэн 3 компани байгаа. Энэ оны 6 сарын 1-ээс гэрээ байгуулаад 9 сар орчимд эхлэх байх. Маршрут бол тогтсон. Энд бид түншлэлийн хувьд

А. Чулуун:

Замаа хувааж бариулах юм уу

Б.Баярсайхан: Замаа бол хуваахгүй. Бид Хятадын 1 компанитай яриж байгаа. Тэр компани нь туслан гүйцэтгэгчээрээ Монголын компаниудыг ажиллуулна гэсэн байр суурьтай байгаа.

А. Чулуун: Замын татварын хувьд...

Б.Баярсайхан: Зам ашигласны татварыг 3Г – тай зөвшилцөх журмаар л явна.

С.Мягмарсүрэн: Том хувьцаа эзэмшигчидтэйгээ хамтарч ажилладаг уу?

Б.Баярсайхан: Том хувьцаа эзэмшигч 2 хүн байгаа. Нэг нь Б.Цогтгэрэл. Энэ хүн бол төрийн ажил хийж байгаа. Гадны эзэмшигчийн хувьд сүүлийн 3-4 сарын хугацаанд хэд хэдэн удаа уулзсан. Өмнө нь бол уулздаггүй байсан бол одоо ирж уулздаг болоод байгаа.

А. Чулуун: Гадны компанид ихэнх хувь нь байгаад байхаар алчих вий гэж бодоход?

Б.Баярсайхан: Миний хувь бол тийм айдас бол одоохондоо алга байна. Аль болох компанийн үйл ажиллагаатай танилцаад төсөл, хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалтад хийгээд явбал хэрэгтэй л байна.

Засгийн Газраас тараах хөрөнгөд бид 3 төсөл өгчихсөн явж байгаа. Мөн бид Укрианы хөрөнгө оруулалттай холбогдсон. Бид төсөлөө танилцуулсан. Харин одоо хэзээ ирж уулзах вэ гээд утасдаад байгаа. 50 сая еврог Монгол улсад төсөвлөчихөөд байгаагаас 15 сая еврог манай төслийг санхүүжүүлэх хүсэлт гаргаад материалаа илгээсэн байгаа. Нааштай шийдэгдэх болов уу гэж найдаад байгаа. Энэ төсөл маань оёдолтой ган хоолойн болон үйлдвэрлэлийн аргаар дулаалгатай хоолойн үйлдвэрлэл юм.

А. Чулуун: Монинжбар ХК – ийн хувьцааг хөрөнгийн бирж дээр алдаг оног зарагдаж байна, эргэлтэнд орж байна. Гэтэл хөрөнгийн оруулалтын эрхийн бичгийн хувьцаатай хүмүүс цэнхэр цаастай хүмүүс болсон байна байх. Тэгэхээр хаанаас хувьцаа гарч ирээд байна вэ? Зарим нь хүмүүс гарах гээд байна уу, зарим нь бичээд авч байна уу?

Б.Баярсайхан: Янз бүр л байдаг байх. Зарим нь худалдан авч байхад, зарим нь хувьцаан дээр тоглолт хийдэг л байх.

А. Чулуун: Тэгэхдээ энд бол нэлээн савалгаа алга л байна л даа. Хувьцаатай байгаад ашиг байна уу?

С.Мягмарсүрэн: Авч байгаа тал нь бол нэлээд урт хугацааг буюу 5 жилийн цаадахыг харж л худалдан авч байгаа байх. Ард нь нэг хувьцаа нэмнэ ч гэдэг юм уу, нэлээн хүлээлттэй хүмүүс их байдаг юм байна лээ. Ногдол ашгийг бол авахгүй. Ер нь бол энэ компанийн хувьцаа яаж өсөх нь вэ? 5 жилийн дараа хэд болох нь вэ гэдэг үүднээс л авч байгаа байх.

А. Чулуун: Энэ компани сайн ажиллаад ирвэл бирж дээр хувьцаа нь өсөөд л ирнэ дээ?

Б.Баярсайхан: Ирээдүйгээ харахад хөгжлийн дээд шатандаа оччиход тендер баримжаалаад суухгүй л байх. Аль болох компанихаа ирээдүйг сайхнаар л харж байгаа. Манай хувьцаа эзэмшигчид нэг үеэ бодвол ирдэг болж байгаа. Японы болон Америкийн хувьцаа эзэмшигчид 3-4 удаа ирж уулзаад, үйл ажиллагаатай танилцаад явсан. Гадныхан манай тендерийн үйл ажиллагааг ойлгодоггүй. Нодлин төсөв хүндрээд улсын төсвөөр хийгдсэн бүх ажлуудын төсөв хойшлогдлоо. Сүүлдээ виксель энэ тэр тараагаад л дууссан. Улс ямар ч хариуцлага хүлээдэггүй.

Б.Баярсайхан: Өөр асуух асуулт юу байна бэ?

Б.Амарбаясгалан: Валютын ханшийн алдагдлын 20-30% - ийг буцаан олгох талаар МҮХАҮТ – аар яригдаад байсан.

Б.Баярсайхан: МҮХАҮТ компаниудынхаа эрх ашгийг хамгаалаад байгуулна гэж үзээд байгаа. Олон улсын форсмажорын нөхцөлөөр ярьвал гэрээний ханшийн алдагдал 30 хувь хүрвэл давагдашгүй эрх болдог юм байна.

С.Мягмарсүрэн: Хэрвээ 20% өгчихвөл бараг 100 сая гаран төгрөг ороод ирэх нь байна.

Б.Баярсайхан: Тэгэхдээ тэрэнд бол итгэл муу л даа. Улс бол хамтран ажиллагч биш.

С.Мягмарсүрэн: Тухайн арилжааны банктай свот хэлцэл байгуулаад ажиллах тухай Монгол банк ярьж байсан.

Б.Баярсайхан: Банкууд бол энэ нөхцөл рүү бараг орж байгаа. Дөнгөж эхлэж байна. Бид иим ажлыг гэрээгээр авлаа танайхаас валютыг тодорхой нөхцөлөөр өнөөдрийн ханшаар нь авъя гээд мөнгө байршуулаад “мөнгөө түгжчихнэ” гэсэн үг.

Б.Амарбаясгалан: Ирээдүйд хүлээх эрсдэлтэй байх үүднээс алдагдал хүлээхгүйн тулд одоо байгаа мөнгөөрөө байршуулж байгаа. Уначих тохиолдолд бол байгууллагад ашиггүй, өсөх тохиолдолд байгууллагад алдагдалгүй байх юм.

А.Чулуун: Алдагдалтай хэрнээ байгууллага дампуурахгүй яаж тэсэж байна вэ?

Б.Баярсайхан: Бид үйл ажиллагаа явуулаагүй биш байнга ажилтай байгаа ашиг маань л тодорхой шалтгааны улмаас бага байгаа юм. Тэрнээс компани дампуурах хэмжээнд хүрээгүй. Бид жил бүр л тодорхой хэмжээний ашигтай ажиллаж байна.

А.Чулуун: Санхүүгийн тайлангаа хэр үнэн бодитой гаргадаг вэ?

Б.Баярсайхан: Манай байгууллага бол санхүүгийн тайлангаа яг л үнэн бодит гаргадаг.

Г.Өлзийсайхан: Бид харилцагч банкнуудаасаа зээл авахад яг л энэ тайлан, болон цалингийн цэсээрээ л явдаг.

Б.Баярсайхан: Бид Хаан банктай сүүлийн жилүүдэд найдвартай хамтран ажиллаж байгаа. Жил бүр зээлийн хүү зээлийг цаг хугацаанд нь төлдөг. Өөрийн хөрөнгөө барьцаалаад /Барилга, тоног төхөөрөмжийн нийт өртөг нь 1.7 тэрбум/ зээл авдаг. Жил бүр квотоо өсгөж өгдөг бөгөөд энэ жил 4 тэрбум төгрөг болгож гэрээ байгуулсан. Үүний 800 сая нь зээлийн шугам, 3.2 тэрбум нь гүйцэтгэлийн баталгааны гэрээ юм. Бид тендерт ороод 3 баталгаа гаргадаг. Тендерт орохдоо Тендерийн баталгаа нь гэж гаргаад тендерт ялбал энэ нь гүйцэтгэлийн баталгаагаар цуцлагддаг, гүйцэтгэлийн баталгаа нь урьдчилгаа төлбөрийн баталгаагаар цуцлагддаг бол урьдчилгаа төлбөрийн баталгаа нь дундын гүйцэтгэлийн баталгаагаар цуцлагдах г.м зарчимаар явдаг учир банк хөнгөлөлттэй үйлчилдэг. Жилийн эцэст ашигласнаасаа шимтгэл /жилийн 3-5%/ төлдөг.

А.Чулуун: Зам тавих ажил гэж байна. Энэ бол маш ашигтай байх гэж бодож байна.

Б.Баярсайхан: Бид 30 жилийн дараа улсад үнэгүй шилжүүлнэ. Энэ хугацаанд ашигаа олох ёстой.

С.Мягмарсүрэн: Ашигаа юугаар олж авах вэ?

Б.Баярсайхан: Бидний тооцоолж байгаагаар дамжин өнгөрч байгаа транзит тээврээр 40 орчим хувийг, 30 хувийг зам дагуу байгуулж байгаа суурингуудаасаа олдог г.м гадны шинжээч болон хуулийн зөвлөхүүд ажиллаж энэ тооцоог гаргаж байгаа.

Б.Амарбаясгалан: Хэдэн жилийн хугацаанд үргэлжлэх вэ?

Б.Баярсайхан: Дуусах хугацаа нь 2016 он. Богино хугацаанд баривал өгөх ашиг нь хурдан байх юм байна.

М.Довдир: 2013 оны ногдол ашигийг тараах уу

Б.Баярсайхан: 50 хувийг нь тараах боломжтой байна гэж үзэж байгаа боловч орж ирэх мөнгөө хүлээгээд байж байгаа.

С.Мягмарсүрэн: 125 сая гаруй төгрөг гээд бодохоор нэг ширхэг хувьцаа бараг 10 төгрөг ногдохоор байна. Тэгэхээр бараг тараагаад дэмий юмбиш үү. Харин буцаагаад

С.Мягмарсүрэн: 125 сая гаруй төгрөг гээд бодохоор нэг ширхэг хувьцаа бараг 10 төгрөг ногдохоор байна. Тэгэхээр бараг тараагаад дэмий юмбиш үү. Харин буцаагаад ажлынхаа явцын хөрөнгө оруулалтад татсан нь дээр юм биш үү. Том хувьцаа эзэмшигчид ашгаа авъя гэдэг үү.

Б.Баярсайхан: Том хувьцаа эзэмшигчид бол /Би Ди Сек, Фан инвестмэнт/ бол цаашдын хөрөнгө оруулалтаа зарцуулж болно гэсэн. Мөн манай томоохон хувьцаа эзэмшигч Цогтгэрэлийн хувьд бол хөрөнгө оруулалтдаа зарцуул гэсэн байр суурьтай байна.

М.Довдир: Хувьцааны хэдэн хувийг нь нээлттэй зарлаад байгаа вэ?

Г.Өлзийсайхан: Ер нь бол 80 орчим хувь нь байгаа. Үлдэж байгаа нь бол чөлөөтэй гэсэн үг.

Б.Баярсайхан: Яг төвлөрөл нь бол 82-83 хувь байдаг.

М.Довдир: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хийж байсан уу?

Б.Баярсайхан: Үгүй. Угаасаа хийж байгаагүй.

Б.Амарбаясгалан: Гадны хөрөнгө оруулалтын тухай тодруулаач

Б.Баярсайхан: Ер нь бол гэрээгээ хийе гээд байгаав Биднээс 2%-ийн урьдчилгаа шаардаж байгаа ХААН банкны хувьд бол татгалзах зүйлгүй боловч хууль эрхзүйн асуудлыг маш сайн судалж үзэх хэрэгтэй гэсэн санал гаргасан. Энэ орж ирвэл бидний хувьд маш их ашигтай. 10 жилийн хугацаатай жилийн 6%-ийн хүүтэй олгогдох хөрөнгө оруулалт юм.

Б.Баярсайхан: Бусад гишүүдэд санал байна уу?

Гишүүд **"байхгүй"** гэснээр ХНХ – ын үйл ажиллагаа өндөрлөлөө.

/Хурлаас гарсан тогтоолуудыг хавсаргав./

ПРОТОКОЛТОЙ ТАНИЛЦСАН:

Хурлын дарга

Хурлын протокол хөтөлсөн:



Б.Баярсайхан

Н.Энхчулуун